

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АГУУЛГА

1. Төслийн танилцуулга	2
2. Уулын ажлын технологийн дэс дараалал	5
3. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга	6
4. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	8
5. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ	11
6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	14
7. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	17
8. Нэг сая модны төлөвлөгөө	19
9. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	25
10. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	25
11. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	26
12. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	26
13. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	29
14. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	31
15. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	35
16. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	37
17. “Багануур” ХК-ийн 2026 оны байгаль орчны ажлын төсөв	39

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр:	“Багануурын хүрэн нүүрсний уурхай”
Төсөл хэрэгжүүлэгч:	“Багануур” ХК, улсын бүртгэлийн дугаар: 9010001045, регистрийн дугаар: 2008572
Төслийн талбайн хэмжээ:	4,778.25 га

Төслийн ерөнхий мэдээлэл		
Аж ахуйн нэгжийн нэр		“Багануур” ХК
Уурхайн байршил		Улаанбаатар хот, Багануур
Ашигт малтмалын төрөл		Хүрэн нүүрс
Ордын төрөл		Стратегийн орд
Тусгай зөвшөөрлийн		
Тусгай зөвшөөрлийн дугаар:	Талбайн нэр:	Талбайн хэмжээ, га:
- MV-001371	- Нарийны тал	- 1,444.06
- MV-013630	- Нарийны тал	- 1.24
- MV-013631	- Нарийны тал-1	- 2,140.81
- MV-021484	- Баруун хонхор	- 1,181.14
Ордын нөөцийн		
Гүйцэтгэсэн хайгуулын ажлууд:		
- Эрлийн ажил		1964 он хүртэлх
- Нарийвчилсан хайгуул		1974-1975 онд
- Гүйцээх хайгуул		1988-1989 онд
- Нэмэлт хайгуул		2014 онд
Ил уурхайн		
Уурхайн жилийн хүчин чадал		
- Нүүрс олборлолт	мян.тн/жил	4,500-8,500
- Хөрс хуулалт	мян.м ³ /жил	16,000-22,500
Ашиглалтын арга		Ил арга

“Багануур” ХК нь анх 1978 онд байгуулагдсан бөгөөд 1995 онд төрийн өмч давамгайлсан хувьцаат компани болж өөрчлөгдсөн. Нийт хувьцааны 75%-ийг төр, 21% ийг АНУ-ын Хайрвет компани, үлдсэн 4%-ийг дотоодын жижиг компаниуд эзэмшдэг. Багануурын нүүрсний уурхай нь 1978 оноос 2025 он хүртэлх хугацаанд жилд дунджаар 3.1-4.9 сая тонн хүрэн нүүрс олборлож, Монгол улсын нүүрсний хэрэгцээний 68%, төвийн түлшний хэрэгцээний 78%-ийг хангадаг байв. 2015 оны 2-р сард 100 дахь сая тонн нүүрсээ олборлосон.



Уурхай одоогийн байдлаар тээвэртэй болон тээвэргүй гэсэн хосолсон системээр Уулын 1-р хэсэг ба Уулын 2-р хэсэг 2 хэсэгт ашиглалтыг явуулж байна. Уулын ажлын өрнөлт нүүрсний давхраасын уналын дагуу болон суналын явагдах бөгөөд нүүрсний уналаа дагаж жил ирэх тусам 4-10м гүнзгийрч байдаг.

Уурхайг ашиглах төслийн гүн 300 метр бөгөөд өнөөдрийн байдлаар уурхайн гүн Уулын 1, 2-р хэсэгт хамгийн их 130 метрт хүрээд байна. Үйлдвэрлэлийн жилийн хүчин чадал 4.5 сая тонн бөгөөд хэрэглэгчдийн хэрэгцээнээс хамаарч 4.8 сая тонн нүүрс олборлож, 21 сая шоо метр хөрс хуулж байна. Жил бүр олборлох нүүрсний хэмжээ нэмэгдэн хөрс хуулалтын хэмжээ нэмэгдэж байгаа үзүүлэлт нь

цаашид уурхайд томоохон хөрөнгө оруулалт шаардлагатай болж байгааг харуулж байна. Ус шүүрүүлэлтийн ажил нь уулын ажлаас 2-3-н жилээр түрүүлж явах онолын үндэслэлтэй байдаг боловч хөрөнгө санхүүгийн хүндрэлээс шалтгаалж жил бүр өрөмдөж ашиглалтад оруулах шүүрүүлэх цооногуудыг шаардлагатай хэмжээгээр өрөмдүүлж чадаагүйгээс шалтгаалж ус шүүрүүлэлтийн ажил өнөөдрийн байдлаар хоцрогдолд ороод байна.

Уурхай гүнзгийрч байгаатай холбогдож уурхайн ашиглалт эхлээгүй газарт ашиглалт явуулж эхлэх зайлшгүй шаардлага гарч байгаа бөгөөд уурхайн зарим хэсэгт ашиглалтын үеийн нарийвчилсан хайгуул хийх ажил нь хөрөнгө мөнгөний хүндрэлтэй байгаа шалтгаанаар өнөөг хүртэл хийгдэж эхлээгүй байна. Уурхайн геологийн 4-р хэсэгт нэмэлт хайгуул хийгдсэн тохиолдолд тус хэсэгт ашиглалт явуулж хөрс хуулалтын хэмжээг багасгах боломж бүрдэх юм. Уурхай гүнзгийрч байгаатай уялдаж жил бүр хуулах шаардлагатай хөрс, шүүрүүлэх ус, өрөмдлөг тэсэлгээний ажлын хэмжээ эрс нэмэгдсээр нүүрсний өөрийн өртгийг нэмэгдүүлж жил ирэх тусам гүний усны хүндрэл болоод хөрс хуулалтын хоцрогдолд оруулж байна.

Байршил: Багануурын хүрэн нүүрсний орд нь Улаанбаатар хотоос зүүн хойш 130 км, Төв аймгийн Баяндэлгэр сумын төвөөс зүүн тийш 15 км зайтай, Тавансувайн талд, Хэрлэн голын савд оршдог. Мааньт өртөөтэй 80 км төмөр замаар холбогддог ба Улаанбаатараас Дорнодын чиглэлд тавигдсан асфальт бетон хучилттай авто зам дайран өнгөрдөг.



Дэд бүтэц: Үйлдвэрийн талбай нь Багануур дүүргээс 4.5км зайтай урд зүгт, уурхайн зүүн хойд талд уурхайгаас 1.4 км зайд байрладаг бөгөөд цахилгаан, дулаан, усан хангамжийн бүх шугамтай бүрэн холбогдсон.

Үйлдвэрлэлийн талбайн хэмжээнд 24 км урттай төмөр зам, "Уул", "Төв", "Галуут" зэрэг цахилгаан хангамжийн гурван дэд станц, тэдгээрээс салбарлан гарсан цахилгаан дамжуулах агаарын шугамууд, УШХ, Уул-2, ТАМАХ оффис, НБАХ-1,2 болон шигших, ангилах байгууламж, ШТС зэрэг дэд бүтцийн гол байгууламжууд үйлдвэрлэлийн талбайд байрлана.

Үйлдвэрлэлийн барилга байгууламжид оффис, ахуй үйлчилгээний газар, хоолны газар, технологийн автомашины засварын хэсэг, үйлчилгээний машинуудын засварын хэсэг, гараж, цахилгаан хангамжийн дэд өртөө, дулаан хангамжийн байгууламжууд, цэвэр бохир усны шугам, сэлбэгийн агуулахууд, гал хамгаалалтын хэсэг, усан сан, компрессорын станцууд болон бусад барилга байгууламжууд байна.

Уурхайн хотхонд 5-9 давхар бүхий барилгууд, нийтийн байр, спорт цогцолбор, хоккейн талбай, Багануур сувилал байрладаг.

Ажиллах хүч: “Багануур” ХК нь 1122 хүний орон тоо бүхий 21 хэсэг, нэгжийн бүтэцтэйгээр тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна. 159 эмэгтэй, 963 эрэгтэй, 291 ажилтан хэвийн, 831 ажилтан хэвийн бус нөхцөлд ажиллаж байна.

Нийт ажилтнуудын удирдлага 24, мэргэжилтэн 38, ажилтан 48, инженер 75, туслах ажилтан 23, үйлчилгээний ажилтан 118, мэргэжлийн ажилтан 821 байна.

Мэргэжлийн ажилтнууд нь цахилгаан экскаваторчин 144, Гагнуурчин 28, Авто засварчин 16, Гүүрэн кранчин 4, Авто механик инженер 34, Уул уурхайн инженер /Уул уурхайн цахилгаан, механик, ашиглалт/ -122, Хүнд машин механизмын оператор - 86, хүнд машин механизмын засварчин-80, уулын тоног төхөөрөмжийн засварчин-55, Илчит тэрэгний машинч-12, Технологийн авто машины Оператор жолооч-108, жолооч 98, төмөр замчин-16, Геологич 2, Цахилгаанчин 47, Өрмийн машинч 24, Сантехникийн засварчин 12, Токарьчин, фрейзерчин12, Тэсэлгээчин 16 ажиллаж байна


Нөхөн сэргээлт: Уул уурхайн үйлдвэрлэлийн технологи үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг нь уурхайлалтын явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажил юм.

Багануур ХК нь 1995 онд уурхайн үйл ажиллагаа хүрээлэн буй орчинд ямар замаар хэрхэн ямар нөлөөлөл үзүүлж байгаад судалгаа хийлгэн тайлан гаргаж, Дэлхийн банкаар зөвшөөрөгдсөнөөр, 1999 оноос Дэлхийн банкны “Монгол нүүрс” төслөөр нөхөн сэргээлтийн ажлыг хэрэгжүүлж эхэлсэн.

1999-2018 оныг хүртэл нийт 212.6 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 190.5 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг хийсэн.

Нийт 190.5 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийснээс 100 га талбайг цаашид өөрөө нөхөн сэргэх боломжтой гэж үзэн орон нутгийн засаг захиргаанд хүлээлгэн өгсөн.

Уулын ажлын технологийн дэс дараалал



ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛ
НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Байгалийн нөхцөл, уур амьсгалын нөхцөл

Газрын гадарга зүй: Физик-газарзүйн мужлалаар Багануур дүүрэг нь Хангай-Хэнтийн уулт их мужийн Хэнтийн хэсэгт, далайн түвшнээс дээш 1200-2000 м өндөрт орших дунд зэргийн уулархаг нутагт хамаарна. Үндсэн рельеф нь баруун хойд талаараа Хэнтийн салбар уулс, зүүн урд талаараа Баян уулын сүлжээгээр хүрээлэгдсэн зүүн хойш чиглэлтэй 810 км, 13-17 км өргөн Баяндэлгэрийн хөндийн зүүн хойд хэсэгт, төвд нь Багануурын уурхай орших Хуцаагийн гол, Хужирын голуудын дэнжийг үүсгэсэн гүвээнүүдээс тогтох Тавансувайн тал юм. Дэнжүүдийн харьцангуй өндөр 10-15м. Талын харьцангуй өндөрлөг зүүн урд намссаар 1376.3 м-ээс (393-р цооног) 13332.9 м (Хужиртын голын хөндий) болно.

Цаг агаар ба уур амьсгал: Агаарын даралтын хэлбэлзэл төдийлөн их биш, 7-р сард 863.2 мм.м.у.б, 8-р сард 870.7 мм.м.у.б. хүрдэг. Агаарын дундаж температур нь олон жилийн дунджаар -3.8°C. Дулааны улиралд +температур 3-9 сар хүртэл 6 сар үргэлжилдэг. 1-р сар хамгийн хүйтэн, дундаж температур нь -27.9°C, хамгийн хүйтэн нь -40°C хүрнэ. 7-р сар хамгийн дулаан, дунджаар 16.9-35°C хүрч халдаг.

Салхи: Салхины ноёлох чиглэл жилийн турш баруун хойноос 26-38%-ийн давтагдалтай, харин 7-р сард хойд чиглэлийнх нь 36% ноёлно. Аль ч улиралд өмнө чиглэлийн салхи 11-16% нэлээд жигд давтагддаг. Хавар салхи ихсэж салхитайгаас салхигүй тохиолдол 39% болсноор агаар дахь тоосонцор, түүнд агуулагдах хийн хольц салхины хүчнээс хамааран урсгалынх нь дагуу зүүн өмнө, зүүн рүү тархаж бохирдлын эх үүсвэр болно.

Хур тунадас, агаарын чийгшил: Агаарын даралтын оронтой холбоотойгоор хүйтэн улиралд бага, дулааны улиралд их буюу жилийн хур тунадасны 90 хувь унадаг нь ойролцоогоор 191 мм болно. Олон жилийн дунджаар дулаан улиралд 50 өдөр бороотой, өвөл 25-30 өдөр цас орно.

Улирлын ба олон жилийн цэвдэг: Багануур дүүрэг орчимд улирлын ба олон жилийн цэвдэг ул хөрс, чулуулаг тархсан байдаг. Хэрлэн гол, түүний цутгал жижиг голуудын хөндийн аллюви пролювийн хурдас их төлөв элс, элсэнцэр чигжээстэй хайрга хайрганцраас бүрэлдэн тогтсон байна. Энэ орчмын хөндийн ул хөрсний температур хасах 0.5 хэмээс нэмэх 1.5 хэм, чийгшилт 5-15%, ул хөрсний эзлэхүүн жинг 150-1700г/см³ тус тус байх нөхцөлд ул хөрсний улирлын хөлдөлт гэсэлтийн гүн 2.7-3.4м байна.

Хөрс: Хөрс нь газарзүйн мужлалаар хүрэн, хар хүрэн хөрстэй Хэрлэнгийн тойрогт багтана. Энэ тойрогт хүрэн хөрс нэн түгээмэл бөгөөд Хэрлэн голын хойд талаар хар хүрэн хөрс уул толгод, ухаа хөндийн ам, хөндийг даган тархана. Уул толгодыг дагаж уулын хар хүрэн хөрс түүнээс доош уулын хүрэн хөрс тархаж, босоо бүслүүр бүдэг илэрнэ. Ухаа гүвээ, хөндий, хотгор, нам тал газар нилдээ хүрэн хөрсөөх хучигдаж ба хонхор, хотгорын ёроолд хужирлаг, мараалаг хөрс тохиолдоно.

Усан сүлжээ: Багануур дүүрэг нь усан сүлжээний хувьд хангалттай, гол горхи, нуур сайтай бүс нутагт хамаарна. Хамгийн том нь уурхайгаас зүүн тийш 15-20 км-т орших Хэрлэн гол юм. Хан Хэнтийн нуруудаас эх авсан Хэрлэн гол дүүргийн нутаг дэвсгэрээр 14 км урсан өнгөрдөг ба өргөн нь 40-100 м, гүн 1-3м, үерлэхдээ үүнээс ч гүн болно. Урсгалын хурд 0.5-1.0 м/с. Ордын талбай дээгүүр Хужир, Хуцаагийн голууд урсан гардаг байсан боловч одоо усгүй болсон. Ордын өмнө захад Багагүн нуур мэт жижиг хэмжээний нуур нэлээд хэд байсан ба уурхайн шүүрүүлж буй уснаас дэмжиж байгаагийн үр дүнд хатаж ширгээгүй байна.

Амьтан: Модлог ургамал зонхилсон ойн сантай газарт хандгай, баавгай, буга, шилүүс, зэрлэг гахай, чоно, үнэг, мануул, хярс, дорго, бор гөрөөс, хүдэр, чандага, тарвага, зурам болон бусад үслэг ан, амьтан элбэг байдаг. Тал хээр газарт алаг даага, бор оготно, үлийн цагаан оготно, мөлхөгчдөөс могой, мэлхий, жижиг гүрвэл: шувуудаас тас, элээ, шар шувуу, харцага, болжмор, хараацай, чогчиго элбэг байхаас гадна дулааны улиралд нүүдлийн шувууд олон төрөл зүйлээрээ ирж нутагшдаг.

Ургамал: Багануур дүүрэг нь хотгорын ландшафтын ангийн тэгш гадаргатай бүлэг төрлийн монголын умард хуурай хээрийн хуримтлалын гадаргатай бүс нутаг юм. Цав тотдгод ба тал газрын нунтаг карбонатлаг хар хүрэн, хүрэн хөрстэй жижиг бутлаг үетэн-хялганат, харгана хялганат хуурайсаг өвс ургамалтай. Ургамал-газарзүйн мужлалаар Евразийн хээрийн их муж, Дагуур- монголын дэд их мужид хамаарагдана. Ургамалжилтын төрх байдал нь уулын ойт хээр, хээрийн ургамлууд зонхилно. Нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд ихэвчлэн хар саарал, хүрэн бор, бор шаргал өнгөтэй элсэрхэг болон хар шороон үржил шим сайтай хөрс давамгайлдаг бөгөөд нэлээд томоохон талбайд тархсан ойн санд шинэс, хуш, улиас, бургас, мөн олон төрлийн жимс зонхилон ургадаг. Энэ нутагт хялгасан дэвхрэгийн цагаан, хохуун холтсон цэцэг, чоно өргөстэй хонгор зул, нарийн навчит зүрхэн цэцэг, инж буурал, туус хонхлой, алтан гагнуур, таван салаа зэрэг эмийн ургамал элбэг байдаг.

Нийгэм, эдийн засаг: Багануур дүүрэг нь 62.2 мянган га нутаг дэвсгэртэй, үүнээс 41.6 мянган га нь ХАА-н, 19.3 мянган га нь хот суурины, 4.71 га нь зам шугам сүлжээний, 14.26 га нь улсын тусгай хэрэгцээний, бусдыг ойн болон усны сан эзэлдэг. Далайн төвшнөөс 1,2761,333 метрт өргөгдсөн. Засаг захиргааны 5 хороо, 8,328 өрхийн 29,341 хүн амтай, МУ-ын хүн амын 0.9%, Улаанбаатар хотын хүн амын 1.9% оршин суудаг. Хүн амын 31.4 хувийг 0-18 хүртэлх насны хүүхдүүд, 50 орчим хувийг хөдөлмөрийн насныхан, үлдсэн 15 гаруй хувийг тэтгэврийн насныхан тус тус эзэлдэг. Нийт өрхийн 41.5 хувь орон сууцанд, 25.8 хувь амины хашаа байшинд, үлдсэн өрх гэрт амьдарч байна.

ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Уул уурхайн үйл ажиллагааны явцад газрын доорхи усны нөөцийн бохирдол, хомсдол, ургамлан нөмрөгийн өөрчлөлт, хөрсний элэгдэл, эвдрэл, геологийн тогтцын өөрчлөлт, зэрлэг ан амьтдын байршилт, тархалтын өөрчлөлт, байгалийн нөөцийн хомсдол, бэлчээрийн талбай багасах, эрчим хүчний хэрэглээ нэмэгдэх, тэрчлэн агаар, ус, хөрсний бохирдол үүсэх, химийн бодисоос үүдэн гарах нөлөөлөл зэрэг сөрөг нөлөөллүүд хамаарна.

Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа нь шинжлэх ухааны үндэслэл бүхий зохион байгуулалт, техникийн арга хэмжээнүүдийг цогц бүрдэл байх бөгөөд эдгээр арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр тухайн уулын үйлдвэр, түүний эргэн тойрон дахь бүс нутагт уулын ажлын явцад экологийн зөвшөөрөгдөх норм, норматив хангагдаж байх ёстой.

Орчны агаарт үзүүлэх нөлөөлөл

Тоосны бохирдол. Хөрс хуулах, тэсэлгээ хийх, нүүрс ба хөрсийг ачиж буулгах, тээвэрлэх зэрэг уурхайлалтын үйл ажиллагааны явцад орчны агаарыг тоосоор бохирдуулах ба уурхайлалтад өртөж эвдэрсэн талбай болон гадаад, дотоод овоолгын сул шороо нь салхи шуурганд тоос болох эх үүсвэр болно. Нүүрс болон хөрс тээвэрлэлтийн авто замыг тогтмол усалж, хайргажуулаагүйгээс тоос босч орчныг бохирдуулна. Уурхайд тэсэлгээ хийснээс газар чичрэх, агаарын хэт даралт үүсэх болон агаарт тоос дэгдэх зэргээр сөрөг нөлөө үзүүлнэ.

Хорт хийн бохирдол. Уурхайд тэсэлгээ хийх, нүүрсний шаталт явагдах, хүнд даацын машин техникийн хөдөлгүүрээс гарах утаанд угаарын хий (CO), азотын дутуу исэл (N₂O), хүхэрлэг хий (SO₂), хүхэрт устөрөгч (H₂S) зэрэг хорт хий ялгаран гарна. Эдгээр хийнүүд зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд төрөл бүрийн хордлого үүсгэнэ.

Газрын гадарга, хөрсөнд үзүүлэх нөлөөлөл

Газрын эвдрэл. Уулын 1, 2 дугаар хэсгийн малталт явуулсан талбай, уурхайлалтын гадна байгуулсан автын овоолго, нүүрс, хөрс тээвэрлэлтийн зам, ус шүүрүүлэлтийн газрын доорхи ба дээрх инженерийн байгууламжуудын далан суваг, уурхайн хил, хамгаалалтын суваг болон уурхайн барилга байгууламж зэрэг газрын дээрхи ба доорхи инженерийн байгууламжуудыг барьж байгуулах, ашиглах явцад газар эвдрэлд орж унаган төрхөө алдана.

Шимт ба шимэрхэг хөрсний хорогдол. Уулын ажил жил бүр уртын дагуу ахилт хийдэг. Шимт ба шимэрхэг хөрсийг 20-50 см хуулж, агуулах байгуулан хадгалах ба шууд хөрсжүүлэх талбайд авч нөхөн сэргээлтэд ашиглах явцад уг хөрсийг дувуу хуулах, хэт зузаанаар хуулж ул шороотой хольж бохирдуулах, шимт хөрсний агуулахыг шаардлага хангахгүйгээр байгуулах, ус бороо салхиар хийсч хорогдох, эргүүлэн нөхөн сэргээлтэд ашиглах хэмжээ нь багасах зэргээр сөрөг нөлөөлөл бий болно.

Өнгөн хөрсний бохирдолт. Уурхайд бензин дизель түлш түгээх 3 станц, төрөл бүрийн тос хүлээн авч хадгалах, түгээх 2 складтай ба тосолгоо үйлчилгээний ажил эрхэлдэг 5 хэсэг цех ажиллаж байна. Эдгээр нь барилга, байгууламжийн орчимд хаягдсан нефть бүтээгдэхүүнээр эргэн тойрны хөрс шороо бохирдох мөн бороо, цаны усаар угаагдан хөрсний усыг бохирдуулах нөлөөтэй.

Хог хаягдлаар бохирдох. Уурхайн үйл ажиллагаа явуулахтай холбогдон ажилчдын хоолны газар, контор, ахуй үйлчилгээний комбинат, үйлдвэрлэлийн цех хэсгүүдээс үйлдвэрийн хог хаягдал гардаг.

Гадаргын болон газрын доорхи усанд үзүүлэх нөлөөлөл

Ил аргаар нүүрс олборлох технологийн дагуу гүний усанд байгаа нүүрсийг олборлохын тулд цооногийн аргаар урьдчилан шүүрүүлж, усны түвшинг нүүрсний давхаргаас доош оруулах аргаар олборлолт явуулдаг. Үүний дагуу жил бүр дунджаар 5 сая.м³/жил гүний ус шүүрүүлэн зайлуулж байна. Гүний усны түвшин буурснаар уурхайлалтын орчны гадаргын болон хөрсний усны түвшин буурч, хөрсөнд хуурайшилт үүсэх нөлөөтэй.

Ордын баруун урд талд байрлах Багагүн нуур, ашиглалтын талбайн хойноос урагшаа байрлалтай Хуцаагийн гол, баруун хэсэгт Хужиртын гол, мөн цөөнгүй тооны булаг шанд, рашаантай. Багагүн нуур нь нүүрсний уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд байдаг бөгөөд уурхайн үйл ажиллагаанаас нуурын усанд сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна. Уурхайн шүүрлийн усаар голын гольдрол, нуурыг тэжээж байгаа нь гадаргын усны найрлага, шинж чанар өөрчлөгдөж болзошгүй.

Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл

Багануурын уурхайн үйл ажиллагааны явцад уурхайн карьер болон овоолгууд уурхайн дэд бүтцийн объектуудыг барих явцад тухайн орчны ургамлан нөмрөг хөрстэй хамт хуулагдана. Мөн замын тоос, шорооноос ургамлан нөмрөгийн өнгө зүс нь алдагдах, навчинд түлэгдэлт үүсэх, эрт унах эрсдлийг бий болгодог. Ургамлын бүрхүүлд бохирдуулах бодисын хуримтлал бий болсноос түүний бодисын солилцооны хэм алдагдах, эсийн бүтцэд өөрчлөлт орох, фотосинтезийн идэвх буурах, өсөлт нь удаашрах, улмаар өсөлт нь бүрмөсөн зогсож ургахаа болих зэрэг байдал бий болдог байна. Эндээс үзвэл ашиглалт явуулж буй хэсэгт ургамлын ургац, амьдрал бүрмөсөн устаж, зарим халцгай буюу талхлагдаж орсон хэсэгт хог ургамал ялангуяа шарилж ихээр ургаж, хүн амьтны амьсгалд тоосны харшил үүсэх нөхцөл болж байна. Ургамлын бүрхэвч устаж үгүй болох нөхцөлд олборлолтын ажил дууссаны дараа уг нутгийн бэлчээрийн нөхөн сэргээх асуудал чухлаар тавигдана.

Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл

Багануурын уурхайд ашиглалт явуулах нь амьтны аймаг, ялангуяа хөхтний байошил, тархац, тоо толгойд шууд нөлөөлнө. Хүн, машин техникийн хөл хөдөлгөөн, дуу чимээ, гэрэл зэргээс орчин тойрны 2-3 км хүртэлх зайд байгаа зарим том хөхтөн дайжиж зайлна. Уурахын үйл ажиллагаанаас амьтны аймагт шууд үзүүлэх нөлөөлөл харьцангуй бага боловч амьтан устах дайжих, орчин тохигүйтэх зэрэг сөрөг нөлөөнөөс үүдэн амьтны аймагт дам нөлөө аль нэг

хэмжээгээр зайлшгүй гардаг. Жижиг мэрэгчээр хооллодог хөхтөн, шувууд тэжээлээ дагаж зурвас нутгийн орчноос холдоно.

Нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

Багануурын нүүрсний уурхайг ашиглах бүхий л хугацааны туршид Багануур дүүргийн иргэд болон тус уурхайн талбайн ойролцоо нүүдлийн мал аж ахуй эрхэлж буй малчин иргэдийн амьдралын хэв маяг, эрүүл мэндэд эерэг болон сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд тодорхой хэмжээний сөрөг нөлөөлөл учруулах боловч улс, орон нутгийн төсвийн орлогын ихэнх хувийг бүрдүүлэх, нийгэм соёлын арга хэмжээ, хандив, тусламж, сайн үйлсийн аян, тогтвортой ажлын байр бий болгож иргэдийн амжиргааны эх үүсвэр болгох, ядуурлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх зэргээр тухайн нутаг дэсвгэрийн нийгэм-эдийн засагт эерэг нөлөөлөл үзүүлэхээр байна.

ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилтууд

1. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах бодлого төлөвлөлтийн баримт бичиг болох БОМ-ийн төлөвлөгөөг журмын дагуу боловсруулан батлуулах, биелэлтийг хангуулан оршин суугчид болон холбогдох газруудад тайлагнаж ажиллах
2. Байгаль орчны чиглэлээр мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн актууд, компаний журам, заавруудыг мөрдлөгө болгох, хуулиар заагдсан зайлшгүй баримт бичгүүдийг хуулийн хугацаанд нь мэргэжлийн байгууллагаар хийлгэж, гарсан заавар, зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа тусгаж ажиллах
3. Байгаль орчны менежментийн тогтолцоо ISO14001:2015 стандартыг нэвтрүүлэх
4. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг арилгах ба хүрээлэн буй орчинд үүсэх эрсдлээс урьдчилан сэргийлэх, хохирлыг хамгийн бага хэмжээнд хүртэл бууруулахад чиглэгдсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх
5. Уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газрын техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг холбогдох аргачлал, стандартын дагуу явуулах, шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, ургамалан бүрхэвч бүрэлдэн тогтмогц орон нутагт хүлээлгэн өгөх
6. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2030 он гэхэд “Нэг сая мод” тарьж ургуулах, газрын доройтлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад хувь нэмрээ оруулж, ногоон хөгжлийг дэмжиж ажиллах
7. Дүйцүүлэн хамгаалахаар тогтоогдсон газар нутагт биологийн олон янз байдлыг хамгаалах, сайжруулахад чиглэгдсэн хамгааллын арга хэмжээ авах
8. Нийгмийн хариуцлагын хүрээнд хүрээлэн буй орчинг хамгаалах чиглэлээр зохицуулах эрх бүхий дээд багууллагууд, орон нутгийн Засаг захиргаа холбогдох албан байгууллагуудтай хамтарч ажиллах
9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, уурхайн үйл ажиллагаа хүрээлэн буй орчинд хэрхэн нөлөөлж байгааг бүртгэн судлах, судалгаа шинжилгээний чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллах
10. Хог хаягдлыг ангилах, хадгалах, дахин ашиглаж байгалийн нөөц баялгийг хэмнэх, хог хаягдал дахин боловсруулахад өгч хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах, аюултай хог хаягдлыг мэргэжлийн байгууллагад шилжүүлэх зэргээр байгаль орчныг бохирдлоос хамгаалах, хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх

Хамрах хүрээ

№	Хуулийн нэр	Батлагтсан огноо	Нэмэлт өөрчлөлт
1	Агаарын бохирдлын төлбөрийн тухай	2012.05.27	2019.11.23
2	Агаарын тухай	2012.05.27	2023.01.06
3	Амьтны тухай	2012.05.27	2023.01.06
4	Ашигт малтмалын тухай хууль	2006.07.08	2023.01.06
5	Байгаль орчныг хамгаалах тухай	2012.05.17	2023.01.06
6	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай	2012.05.17	2023.01.06
7	Байгалийн ургамлын тухай	2012-05-17	2023.01.06
8	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай	2012.05.17	2023.05.04
9	Газрын тухай хууль	2012.05.17	2023.11.10
10	Газрын төлбөрийн тухай	1997-04-24	2023.11.10
11	Галын аюулгүй байдлын тухай	2012-05-17	2023.01.06
12	Гамшгаас хамгаалах тухай	2017-02-02	2023.07.07
13	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай	2012.05.17	2022.11.11
14	Хог хаягдлын тухай	2017.05.12	2023.01.06
15	Усны тухай	2012.05.17	2023.01.06
16	Ус бохирдуулсны төлбөрийн тухай	2012.05.17	2022.06.03
17	Ургамал хамгааллын тухай	2007-11-15	2023.01.06
18	Соёлын тухай	1995.04.17	2023.01.06
19	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай	2013.01.31	2023.01.06
20	Эрүүл ахуйн тухай	2016.02.04	2023.07.07

№	Баримт бичгийн дугаар	Стандартын нэр
Агаарын чанар		
1	MNS 5885:2008	Агаарын байх бохирдуулагч бодисын хүлцэх хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага
2	MNS 4585:2016	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
3	MNS 3383:1982	Агаарын мандал. Бохирдлын эх үүсвэр. Нэр томьёо. Тодорхойлолт
4	MNS (ISO) 4226:2000	Агаар чанар. Ерөнхий ухагдахуун, хэмжих нэгж
5	MNS 5387:2004	Ажлын байрны агаар. Ажлын байрны агаарын температур чийгийг хэмжих арга
6	MNS 0017-5-1-21:1992	Авто тээврийн хэрэгслийн дуу чимээ. Дуу чимээний хүлцэх төвшин, хэмжих арга
7	MNS ISO 5128:2005	Машин механизмын бүхээг доторх дуу чимээ түвшнийг тодорхойлол
Ус		
8	MNS 0900-2018	Ахуйн хэрэгцээ, ундны зориулалттай ус. Хээрийн шинжилгээний арга, MNS 3936-86 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тваих хяналт
9	MNS 0017-1-1-14-80	БОХ. Усан мандал. Ус ашиглалтын ангилал
10	MNS 3342:1982	Усан мандал. Газрын доорхи усыг Бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага
11	MNS 4047:98	Усан мандал гадаргын усны чанарыг хянах журам
12	MNS 4586-98	Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага
13	MNS 6148-2010	Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
14	MNS 3934-1986	Унд ахуйн хэрэгцээний болон үйлдвэрийн ус хангамжийн зориулалттай ус. Химийн шинжилгээний арга. Дээж авах, хадгалах тээвэрлэх.
15	MNS 1306107-1:2002	Усны чанар

16	MNS 4943:2011	Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага
17	MNS 5667-11-2000	Гүний уснаас дээж авах зөвлөмж
18	MNS 4867:1999	Усны чанар. Дээж авах 3-р хэсэг. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж
19	MNS (ISO)5667-1:2002	Усны чанар. Дээжлэлт. Хэсэг 1. Дээжлэлтийн хөтөлбөр боловсруулах удирдамж
20	MNS (ISO)5667-2:2002	Усны чанар. Дээжлэлт. Хэсэг 2. Дээжлэлтийн аргачлалын удирдамж
21	MNS (ISO) 4867:1999	Усны чанар. Дээжлэлт. Хэсэг 3. Дээж бэлтгэх ба хадгалах зөвлөмж
22	MNS (ISO) 5667-10:2001	Усны чанар. Дээжлэлт. Хэсэг 10. Бохир усны дээжлэлтийн журам
23	MNS (ISO) 5667-11:2000	Усны чанар. Дээжлэлт. Хэсэг 11. Гүний усны дээжлэлтийн журам
24	MNS 3597:83	Усан мандал. Гадаргуугийн ба газрын доорх усыг эрдэс бордооны бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага
Хөрс, ургамал		
25	MNS 3473-83	БОХ. Газар. Газар эдэлбэр. Газар ашиглалт
26	MNS 4917-2008	Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс
27	MNS 5918-2008	Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага
28	MNS 3298-91	Хөрснөөс шинжилгээнд дээж авахад тавигдах шаардлага
29	MNS 5850-2019	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
30	MNS 5916:2008	Байгаль орчин. Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт техникийн шаардлага
31	MNS 4919:2000	Байгаль орчин. Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага
32	MNS 0017-0-0-06:1979	Байгаль орчны хамгааллын стандартын систем. Үндсэн дүрэм
33	MNS 4920:2000	Байгаль орчин. Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага
34	MNS 0017-5-1-13:1980	Эвдэрсэн газрын сэргээн сайжруулалт. Нэр томьёо, тодорхойлолт
35	MNS 0017-5-1-19:1992	Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийхэд тавигдах ерөнхий шаардлага
36	MNS 5914:2008	Байгаль орчин. Газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт
37	MNS 3297:1991	Хөрс. Эрүүл ахуйн үзүүлэлтүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ
38	MNS 3307:91	Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга
Нөхөн сэргээлт		
53	MNS 5914:2008	Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт
54	MNS 5916:2008	Байгаль орчин. Үржил шимт хөрсийг хуулах шаардлага
55	MNS 5918:2000	Байгаль орчин. Эвдэрсэн газрыг дахин ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага
56	MNS 4919:2000	Байгаль орчин. Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага
57	MNS 4920:2000	Байгаль орчин. Эвдэрсэн газрын хажуу хананд тавигдах техникийн шаардлагууд

5. Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэм/нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэг-жүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1	Агаарын чанар	Уурхайн дотоод тээврийн замуудыг эвдрэл гарсан тухай бүр сэргээн засч тэгшлэх, шаардлагатай замуудыг хайргажуулах, ус зайлуулах далан суваг хийх	Уурхайн дотоод тээврийн зам	м	-	15,000	Үйл ажиллагааны зардал	3-11-р сар	БОННУ Тайлан 2019он Агаарын тухай хууль
		Уурхайн дотоод тээврийн замын тоосыг дарах усалгааг тогтмол хийх хяналт тавих	Уурхайн дотоод тээврийн зам	км м³	-	30,000 85,000	Үйл ажиллагааны зардалд	3-11-р сар	
		Машин техникийн хурдны хязгаарт хяналт тавих, GPS хяналтыг тогтмол хийх	Үйлчилгээний машинууд болон автосамосвалууд	-	-	-	ХАБЭАХ Цалингийн зардал	Байнга	БОННУ тайлан 2019 он
